



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/286

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжих Хэрлэн сумын сүрьеэгийн эмнэлгийн барилгын зураг төсөл, Өлзийт тосгоны эмнэлгийн барилгын зураг төсөв, Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын зураг төсөв, Байгаль орчин, Хэрлэн голын сав газар, Ус цаг уур орчны шинжилгээний газрын барилгын зураг төсвийн зөвлөх үйлчилгээний ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:		
Дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүн:	Э.Дэлгэрмаа	-Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Д.Баттулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА